



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Говь-Алтай-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 48,500,000.00 (дөчин найман сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 41,225,000.01 (дөчин нэгэн сая хоёр зуун хорин таван мянган төгрөг нэг мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Говь-Алтай аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Говь-Алтай-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ш.Тогтмол, Говь-Алтай аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батсанчир нарт дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлэн бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 132001096

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2022 оны 01
дүгээр сарын 06-ний өдрийн
тогтоолын хавсралт

**"Говь-Алтай" АЗЗА ТӨХК-ийн балансаас Говь-Алтай аймаг дахь
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн балансад шилжүүлэн
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиг лал танд орсон он	Тоо шир хэг	Балансын дүн (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	ZL маркийн, УБ 80-64 улсын дугаартай, трактор, арлын дугаар - 8030036		1	48,500,000.00	41,225,000.01	7,274,999.99
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)	48,500,000.00 (дөчин найман сая таван зуун мянган)	41,225,000.01 (дөчин нэгэн сая хоёр зуун хорин таван мянган төгрөг нэг мөнгө)	7,274,999.99 (долоон сая хоёр зуун далан дөрвөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерөн есөн мөнгө)